



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/187/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: Ц.Цэрэнхүү
Утас: 261740 Цахим хаяг: tserenkhuuts@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Мөнгөн оршдос Аудит ХХК
Захирал: Ц.Таванчулуу
Утас: 99177464 Цахим хаяг: tavanchuluu.ts@moaudit.com

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.СҮХБААТАР ТАНАА

2022-02-25 № 07/400

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх г зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	<u>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</u>	<u>191,824,254.77</u>	<u>331,421,287.27</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	191,824,254.77	331,421,287.27
35300	Бэлэн бүтээгдэхүүн	127,548,301.35	217,097,306.35
35400	Хангамжийн материал	64,275,953.42	114,323,980.92
35410	Бичиг хэргийн материал	11,839,035.00	14,687,935.00
35420	Аж ахуйн материал	44,886,677.50	89,883,985.00
35430	Сэлбэг хэрэгсэл	196,680.00	0.00
35440	Түлш,шатах тослох материал	3,355,000.00	5,753,500.00
35470	Бусад хангамжийн материал	3,998,560.92	3,998,560.92
II	<u>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</u>	<u>7,092,127,768.89</u>	<u>5,223,894,771.34</u>
39	<u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u>	<u>7,092,127,768.89</u>	<u>5,223,894,771.34</u>
39200	Биет хөрөнгө	6,972,749,455.89	5,104,598,958.34
39201	Барилга,байгууламж,орон сууц	5,440,864,311.00	5,440,864,311.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(729,528,360.12)	(838,607,805.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	158,112,170.00	158,112,170.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(119,162,170.00)	(131,462,170.00)
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	7,644,569,976.17	7,716,534,163.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,473,807,005.82)	(7,295,074,792.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	364,980,693.06	425,578,177.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	(321,946,824.84)	(378,011,763.15)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,333,333.56)	(13,333,333.60)
39300	Биет бус хөрөнгө	119,378,313.00	119,295,813.00
39301	Программ хангамж	3,530,000.00	3,530,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,296,250.00)	(3,378,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	119,144,563.00	119,144,563.00
III	<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u>	<u>7,283,952,023.66</u>	<u>5,555,316,058.61</u>
V	<u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН</u>	<u>7,283,952,023.66</u>	<u>5,555,316,058.61</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,849,976,358.38	6,849,976,358.38
51101	Засгийн газрын оруулсан капитал	6,849,976,358.38	6,849,976,358.38
51200	Хуримтлагдсан үр дүн	432,525,442.43	-1,296,110,522.62
51210	Өмнөх үеийн үр дүн		432,525,442.43
51220	Тайлант үеийн үр дүн		-1,728,635,965.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,450,222.85	1,450,222.85
VIII	<u>НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</u>	<u>7,283,952,023.66</u>	<u>5,555,316,058.61</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,700,498,547.10	5,002,765,165.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	355,730,547.10	337,718,165.73
120	Нийтлэг татварын бус орлого	350,751,047.10	337,718,165.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	290,669,143.50	267,936,991.73
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	290,669,143.50	267,936,991.73
120005	Түрээсийн орлого	60,081,903.60	69,781,174.00
122	Тусламжийн орлого	4,979,500.00	0.00
122001	Хандив тусламж /дотоод	4,979,500.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,344,768,000.00	4,665,047,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,344,768,000.00	4,615,047,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,344,768,000.00	4,615,047,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	50,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	50,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,326,211,254.05	6,731,354,710.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,326,211,254.05	6,731,354,710.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,169,554,419.58	6,594,204,349.37
21	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	3,916,570,308.38	4,201,035,579.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,475,258,860.12	3,715,819,972.22
210101	Үндсэн цалин	3,325,416,860.12	3,482,384,972.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	149,842,000.00	233,435,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	441,311,448.26	485,215,607.31
210201	Тэтгэврийн даатгал	302,267,080.99	337,120,775.41
210202	Тэтгэмжийн даатгал	28,233,198.48	37,023,708.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	34,633,910.60	29,618,965.54
210204	Ажилгүйдлийн даатгал	6,927,497.16	7,404,742.16
210205	Эрүүл мэндийн даатгал	69,249,761.03	74,047,415.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,113,557.90	49,687,478.51
210301	Гэрэл, цахилгаан	34,542,973.00	29,480,519.93
210302	Түлш, халаалт	20,308,714.89	15,929,065.57
210303	Цэвэр, бохир ус	3,261,870.01	4,277,893.01
2104	Хангамж, бараа материалын зардал	45,001,053.84	45,597,215.00
210401	Бичиг хэрэг	25,840,332.00	21,867,440.00
210402	Тээвэр, шатахуун	7,692,000.00	9,837,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,916,123.84	2,515,424.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	779,500.00	732,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,773,098.00	10,645,351.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,214,553.00	228,405,103.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	378,200.00	175,350.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	9,110,450.00	209,450,240.00
210604	Урсгал засвар	32,725,903.00	18,779,513.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	134,333,771.38	84,514,074.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,326,257.13	39,192,922.55
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,336,868.00	2,169,615.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	383,998.75	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	53,198,647.50	40,063,536.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,973,321,175.08	1,984,964,899.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,771,562.28	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,593,272.73	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,932,956,340.07	1,984,964,899.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156,656,834.47	137,150,361.41
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	156,656,834.47	109,237,912.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	156,656,834.47	109,237,912.61
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	27,912,448.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	27,912,448.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-1,625,712,706.95	-1,728,589,545.05
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	46,420.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	46,420.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-1,625,712,706.95	-1,728,635,965.05

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	2,058,238,149.38	8,909,664,730.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-1,625,712,706.95	-
2020 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	432,525,442.43	7,283,952,023.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-1,728,635,965.05	-
2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	-1,296,110,522.62	5,555,316,058.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,411,566,784.00	4,734,828,174.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,798,784.00	69,781,174.00
120	Нийтлэг татварын бус орлого	66,798,784.00	69,781,174.00
120005	Түрээсийн орлого	66,798,784.00	69,781,174.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,344,768,000.00	4,665,047,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,344,768,000.00	4,615,047,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,344,768,000.00	4,615,047,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	50,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	50,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,411,566,784.00	4,649,278,894.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,916,570,308.38	4,512,128,532.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,233,240,844.73	4,512,128,532.59
21	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	3,916,570,308.38	4,201,035,579.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,439,139,808.38	3,694,687,079.53
210101	Үндсэн цалин	1,871,823,608.38	1,931,923,183.71
210102	Нэмэгдэл	926,086,800.00	1,045,697,800.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	209,229,400.00	289,066,095.72
210104	Урамшуулал	432,000,000.00	428,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	477,430,500.00	506,348,500.00
210201	Тэтгэврийн даатгал	351,969,600.00	355,915,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	31,365,200.00	24,069,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	25,092,200.00	60,173,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,273,000.00	6,017,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	62,730,500.00	60,173,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,265,357.90	49,687,478.51
210301	Гэрэл, цахилгаан	34,694,773.00	27,077,680.34
210302	Түлш, халаалт	20,308,714.89	18,331,905.16
210303	Цэвэр, бохир ус	3,261,870.01	4,277,893.01
2104	Хангамж, бараа материалын зардал	49,358,888.84	47,862,426.00
210401	Бичиг хэрэг	19,728,600.00	22,356,950.00
210402	Тээвэр, шатахуун	8,375,000.00	11,375,500.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,916,123.84	2,515,424.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	731,100.00	732,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,608,065.00	10,882,552.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,801,500.00	131,207,396.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,681,600.00	7,366,696.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	12,084,600.00	53,990,700.00
210604	Урсгал засвар	58,035,300.00	69,850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	103,247,666.88	82,211,652.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,949,999.73	46,422,111.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,014,168.00	1,910,215.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	309,200.00	259,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	101,500.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,099,999.15	9,940,697.75
210807	Газрын төлбөр	591,800.00	591,228.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,181,000.00	20,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,997,122.73	124,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,997,122.73	124,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	178,325,939.27	137,150,361.41
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	156,656,834.47	109,237,912.61

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	156,656,834.47	109,237,912.61
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,669,104.80	27,912,448.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,669,104.80	27,912,448.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	85,549,280.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	85,549,280.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	85,549,280.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	85,549,280.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	85,549,280.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-85,549,280.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00
25	ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
IX	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.00	0.00
X	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,677,047,000.00	4,547,683,512.59	129,363,487.41	97.2
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,677,047,000.00	4,547,683,512.59	129,363,487.41	97.2
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,677,047,000.00	4,547,683,512.59	129,363,487.41	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,913,500.00	346,647,933.06	48,265,566.94	87.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	3,775,785,000.00	3,694,687,079.53	81,097,920.47	97.9
210101	Үндсэн цалин	2,009,152,800.00	1,931,923,183.71	77,229,616.29	96.2
210102	Нэмэгдэл цалин	1,045,697,800.00	1,045,697,800.10	-0.10	100.0
210103	Унаа хоолны нэмэгдэл	292,934,400.00	289,066,095.72	3,868,304.28	98.7
210104	Урамшуулал	428,000,000.00	428,000,000.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	506,348,500.00	506,348,500.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	355,915,000.00	355,915,000.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	24,069,400.00	24,069,400.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	60,173,400.00	60,173,400.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	6,017,300.00	6,017,300.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	60,173,400.00	60,173,400.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,948,000.00	49,687,478.51	46,260,521.49	51.8
210301	Гэрэл, цахилгаан	66,400,000.00	27,077,680.34	39,322,319.66	40.8
210302	Түлш, халаалт	25,394,400.00	18,331,905.16	7,062,494.84	72.2
210303	Цэвэр, бохир ус	4,153,600.00	4,277,893.01	-124,293.01	103.0
2104	Хангамж, бараа материалын зардал	49,054,000.00	47,862,426.00	1,191,574.00	97.6
210401	Бичиг хэрэг	22,357,000.00	22,356,950.00	50.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	11,375,500.00	11,375,500.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,589,500.00	2,515,424.00	1,074,076.00	70.1
210405	Хог, хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	732,000.00	732,000.00	0.00	100.0
210406	БҮТЭЗүйлс	11,000,000.00	10,882,552.00	117,448.00	98.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	157,906,000.00	157,889,976.00	16,024.00	100.0
210601	Багаж, техник хэрэгсэл	18,906,000.00	18,899,276.00	6,724.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	54,000,000.00	53,990,700.00	9,300.00	100.0
210604	Урсгал засвар	85,000,000.00	85,000,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,855,500.00	91,084,052.55	771,447.45	99.2
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,556,000.00	55,294,511.80	261,488.20	99.5
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,258,000.00	1,910,215.00	347,785.00	84.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	309,500.00	259,400.00	50,100.00	83.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	140,000.00	88,000.00	52,000.00	62.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,000,000.00	9,940,697.75	59,302.25	99.4
210807	Газрын төлбөр	592,000.00	591,228.00	772.00	99.9
210809	Улсын мэдээллийн маягт	20,000,000.00	20,000,000.00	0.00	100.0

	хэвлэх, бэлтгэх				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,000.00	124,000.00	26,000.00	82.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00	124,000.00	26,000.00	82.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	0.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,677,047,000.00	4,547,683,512.59	129,363,487.41	97.2
120	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,000,000.00	69,781,174.00	-7,781,174.00	112.6
120005	Төрийн өмч түрээслүүлсний орлого	62,000,000.00	69,781,174.00	-7,781,174.00	112.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,615,047,000.00	4,477,902,338.59	137,144,661.41	97.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,615,047,000.00	4,477,902,338.59	137,144,661.41	97.0
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0.00	0.00	0.00	
	Байгууллагын тоо	1	1		
	Ажиллагсад бүгд	189	215	-26	113.8
9001	Удирдах ажилтан	3	2	1	66.7
9002	Гүйцэтгэх ажилтан	163	189	-26	116.0
9003	Үйлчилгээний ажилтан	23	24	-1	104.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		50,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		50,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		49,994,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		49,994,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		21,240,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл		21,240,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		28,754,300.00
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		28,754,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		5,700.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,700.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		50,000,000.00
120	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		50,000,000.00
132000	Орон нутгийн төсвөөс санхүүжих		50,000,000.00
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримтын бүрдэл болон худалдан авалтын цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Мөнгөн оршдос Аудит ХХК-ийн аудитор Б.Тамир, аудиторын туслах Г.Содбилэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Отгонцэцэг, захирал Ц.Таванчулуу нар хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мөнгөн оршдос аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 02/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Улаанбаатар хот дахь Гаалийн газар нь гаалийн байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг гаалийн бодлого, тэргүүлэх чиглэл, стратегитай уялдуулан хөгжүүлж, өргөжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- ГЕГ-ын даргын 2021.08.04-ний өдрийн А/172 тушаалаар “Албан хаагчдад олгох хоол унааны хөнгөлөлтийг шинэчлэн тогтоох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/272 дугаар тушаалаар баталсан “Гаалийн газар, харьяа газар, хороодын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх” Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг мөрдсөн байна.

Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн дагуу 2021 оны 1 дүгээр улиралд Сангийн яамнаас төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтаар тус гаалийн газрын 2019 он, 2020

оны санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар төсөв, санхүү нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал гараагүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар хот дахь Гаалийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүнг сонгож 4,233,240.8 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 84,664.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,728,635.97 мянган төгрөгөөр буюу 23.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэлд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Бараа материал	191,824.3	331,421.3	139,597.0
Үндсэн хөрөнгө	7,092,127.7	5,223,894.7	(1,868,233.0)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,283,952.0	5,555,316.0	-1,728,636.0
Засгийн газрын хувь оролцоо	6,849,976.4	6,849,976.4	-
Хуримтлагдсан үр дүн	432,525.4	(1,296,110.5)	1,728,635.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,450.2	1,450.2	-
НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,283,952.0	5,555,316.1	1,728,635.9

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 331,421.3 мянган төгрөг болж 139,597.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 236,754.3 мянган төгрөгийн бараа материал, худалдан авсан 219,086.1 мянган төгрөгийн бараа материал;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,223,894.7 мянган төгрөг болж 1,868,233.0 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын зөвшөөрлөөр 21,626.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан, тайлант онд барилга байгууламжийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 1,984,964.9 мянган төгрөг гарсан;

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт /мянган төгрөг/
А	1	2	3=2-1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	290,669.1	267,936.9	(22,732.2)
Түрээсийн орлого	60,081.9	69,781.2	9,699.3
Хандив тусламж /дотоод	4,979.5	-	(4,979.5)
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,344,768.0	4,615,047.0	270,279.0
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	50,000.0	50,000.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,700,498.5	5,002,765.1	302,266.6
Цалин хөлс,НДШ	3,916,570.3	4,201,035.6	284,465.3
Бараа үйлчилгээний зардал	145,329.2	323,689.8	178,360.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	134,333.8	84,514.0	(49,819.7)
Бараа үйлчилгээний бусад зардал	1,973,321.2	1,984,964.9	11,643.7
Төвлөрүүлэх шилжүүлэг	156,656.8	137,150.4	(19,506.5)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,326,211.3	6,731,354.7	405,143.4

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 302,266.6 мянган төгрөг буюу 6.4 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 405,143.4 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна. Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж бараа материал, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал зэрэг зардлууд өмнөх оны үзүүлэлтээс өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахлын үед онцгой нөхцөлд ажилласан ажиллагсдын унаа, хоолны зардал, цалин хөлс, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,245,539.1 мянган төгрөг, нийт зарлагыг 5,245,539.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,439,306.5 мянган төгрөгөөр бууруулж 3,806,232.5 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн захирагч төсвийн төслийг бодитой төлөвлөөгүй байна.

Тайлант онд төсөвт тодотгол хийж зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 4,677,047.0 мянган төгрөг болгож төсвийг 870,814.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,677,047.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 4,615,047.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 62,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр түрээсийн орлогоос 69,781.2 орлого бүрдүүлж, улсын төсвөөс 4,615,047.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны зардалд 4,547,683.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 109,232.2 мянган төгрөгийг улсын төсөвт, түрээсийн орлогын 27,912.4 мянган төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,547,683.5 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 77,229.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1,191.6 мянган төгрөгөөр, байр ашиглалтай холбоотой зардлыг 46,260.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 0.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
	Код	Нэр				
1	70205	Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	62,000.0	69,781.2	7,781.2	112.5
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,592,885.0	4,525,782.9	67,102.1	98.5
1.2	80219	Харуул хамгаалалтын зардал	21,400.0	21,210.0	190.0	99.1
1.3	80220	Холбооны суваг ашигласны төлбөр	762.0	690.6	71.4	90.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2021 оны 23 дугаар захирамжаар гаалийн зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цахим самбар байршуулах, хууль тогтоомжийн өөрчлөлт шинэчлэлийг аж ахуйн нэгж, иргэнд зориулан сурталчлах, гарын авлагаар хангах ажлыг зохион байгуулахад 50,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Үүнээс, эд хогшил худалдан авах зардалд 21,240.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 28,754.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад цалин хөлс, НДШ, нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмжээс бусад төрлийн зардлын хувьд тогтмол зардлыг 48 хувь буюу 46,260.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2.4 хувь буюу 1,191.6 мянган төгрөгөөр нийт

47,452.1 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Энэ нь ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1.1, 1.8 заалтуудыг хэрэгжүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын зарим заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Бусад асуудлын хэсэг:

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанбаатар хот дахь Гаалийн газар нь 2021 онд нийт 90,184.2 мянган төгрөгийн 138 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн холбогдох мэдээлэл нь бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн ГЕГ-ын даргын 2017 оны А/249 тоот тушаалд заасан батлагдсан бүтэц орон тооны хязгаарыг баримталж ажиллах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, 1 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	2	4,210.9	1	4,210.9	-	-	50.0
Нийт дүн	2	4,210.9	2	4,210.9	1	-	50.0

Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/249 тоот тушаалд заасан батлагдсан бүтэц, орон тооны хязгаарыг баримталж ажиллах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3. "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, хэрэгжүүлэх" талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/249 тоот тушаалаар "Зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалын 2 дугаар хавсралтаар Улаанбаатар хот дахь Гаалийн газрыг 189 орон тоотой байхаар баталсан. Тайлант онд тус гаалийн газар нь батлагдсан орон тоог 26-аар хэтрүүлсэн буюу 227,995.3 мянган төгрөгийн цалингийн зардал гарсан байна. 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан орон тоо, гүйцэтгэлийн талаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,185.7 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 4,185.7 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 84,664.8 мянган төгрөгөөс хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд төсвийн зориулалт зөрчин бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 3,093.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн эрх үүрэг ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх;

2. Худалдан авалттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Дансны хуулга, төлбөрийн цахим баримтыг тулган шалгахад тайлант хугацаанд хийгдсэн худалдан авалт, ажил үйлчилгээний төлбөрийн 1,091.8 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтгүй (9 бэлтгэн нийлүүлэгч байгууллага э-баримтыг цахим системд дутуу бүртгүүлсэн) шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэлд тусгахгүй байх, төлбөрийн цахим баримтыг тухай бүр нь бүрдүүлж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс			
							Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар										
1	УБ хот дахь Гаалийн газар	АХГ-2022/187/НА-СТА-ТШЗ	Бусдаар гүйцэт-гүүлсэн бусад нийтлэг үйлчил-гээний төлбөр хураамжийн зардлаас үндсэн хөрөнгө бэлдсэн байна.	Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй ажиллах	1	3,093.9			1	3,093.9
2	УБ хот дахь Гаалийн газар	АХГ-2022/187/НА-СТА-ТШЗ	Тайлант онд 9ААН-ийн худалдан авалт, ажил үйлчилгээний төлбөрийн цахим баримт байхгүй, баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна.	Худалдан авалт, ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах	1	1,091.8			1	1,091.8
Дүн					2	4,185.7			2	4,185.7

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting or typing. There are no margins, text, or other markings on the page.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.